# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 01 өдөр Дугаар А/677 Номгон

Коронавирусын халдварын үед сумдад нэмэлт
Ор дэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.6 “л”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 10.4.10, 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Коронавирусын халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдэж, сумдын эрүүл мэндийн төвүүдийн ачаалал ихсэж байгаа тул иргэдийг хэвтүүлэн эмчлэх боломжтой барилга байгууламжийг стандартад нийцүүлэн тохижуулж, тусгаарлан эмчлэх байрыг хавсралтад заагдсан сум, газар зүйн байршил, дэлгэх орны тоогоор дайчлан нэмэлтээр эмнэлэг дэлгэн ажиллуулсугай.

2.Тусгаарлан эмчлэх байрны халдварын сэргийлэлт, хяналт, аюулгүй ажиллагаа, бэлэн байдлыг хангуулж, хамтарсан ажлын хэсгийн дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Онцгой байдлын газар (Алтангэрэл), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус даалгасугай.

3.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

601?10579

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн A/09 дугаар захирамжийн хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ТАЙ ИРГЭНИЙГ ЭМЧЛЭХЭД 20 СУМДАД ДЭЛГЭХ ТУСГААРЛАН ЭМЧЛЭХ БАЙРНЫ ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, ОРНЫ ТОО

| № | Сумдын нэрс | Эмнэлгийн нөхцөлд дэлгэсэн ор | | Эмнэлгийн бус нөхцөлд дэлгэх ор | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | Үндсэн батлагдсан орны тоо | Нийт | | |
| 1 | Өлзийт сум | 12 | 12 | 20 | Хуучин эмнэлгийн байр |
| 2 | Баяновоо сум | 10 | 10 | 30 | Хуучин цэцэрлэг |
| 3 | Эрдэнэцогт сум | 17 | 17 | 50 | Соёл спортын төвийн байр |
| 4 | Шаргалжуут сум | 8 | 8 | 20 | Шаргалжуут рашаан сувиллын Эко байр |
| 5 | Жинст сум | 10 | 10 | 20 | Соёлын төв |
| 6 | Богд сум | 13 | 13 | 40 | Соёлын төв |
| 7 | Баянлиг сум | 16 | 16 | 40 | Соёлын төв |
| 8 | Баянговь сум | 13 | 13 | 40 | Соёлын төв |
| 9 | Баян-Өндөр сум | 12 | 12 | 50 | Эмнэлгийн хуучин байр |
| 10 | Шинэжинст сум | 12 | 12 | 20 | Соёлын төв |
| 11 | Баянцагаан сум | 15 | 15 | 30 | Хуучин эмнэлгийн байр |
| 12 | Баацагаан | 14 | 14 | 50 | Соёлын төв |
| 13 | Бөмбөгөр | 14 | 14 | 40 | Цэцэрлэг ЕБС-ийн дотуур байр |
| 14 | Хүрээмарал | 10 | 10 | 40 | Сургуулийн дотуур байр |
| 15 | Бууцагаан | 14 | 14 | 40 | Соёлын төв |
| 16 | Баянбулаг | 10 | 10 | 10 | Тамгын газрын хуучин байр |
| 17 | Гурванбулаг | 12 | 12 | 50 | Соёлын төв |
| 18 | Заг | 11 | 11 | 40 | Тамгын газрын буудал, хуучин эмнэлгийн байр |
| 19 | Жаргалант | 13 | 13 | 50 | Ахуй үйлчилгээний байр |
| 20 | Галуут | 17 | 17 | 70 | Хуучин эмнэлгийн байр |
| Нийт | | 253 | 253 | 750 | |

.................оОо..............